

НЭГ. SOCIALPAY_ерөнхий ойлголттой холбоотой

- 1.1. [Social Pay гэж юу вэ?](#)
- 1.2. [Үйлчилгээний боломжууд](#)
- 1.3. [Үйлчилгээний нөхцөл](#)
- 1.4. [Аппликейшн хэрхэн татаж авах вэ?](#)
- 1.5. [Аппликейшн татаж авахад төлбөртэй юү?](#)
- 1.6. [Аппликейшн татаж авахад ашигладаг нууц үгээ мартсан бол яах вэ?](#)
- 1.7. [Хэрхэн бүртгүүлэх вэ?](#)
- 1.8. [Утсанд тавигдах шаардлага](#)
- 1.9. [Утасныхаа version-г хэдээс дээш байгааг яаж мэдэх вэ?](#)
- 1.10. [Ухаалаг утасгүй бол яах вэ?](#)
- 1.11. [Хэрхэн аппликэйшндээ нэвтрэх вэ?](#)
- 1.12. [Сошиал данс гэж юу вэ?](#)
- 1.13. [Ямар данс холбож болох вэ?](#)
- 1.14. [Шилжүүлсэн мөнгө хэзээ нөгөө дансандаа орох вэ?](#)
- 1.15. [Сошиал пин гэж юу вэ?](#)
- 1.16. [Хэрхэн аппликэйшнаасаа гарах вэ?](#)
- 1.17. [SocialPay-ээр шилжүүлсэн мөнгө болон нэхэмжлэхийн талаар нөгөө хүн маань яаж мэдэх вэ?](#)
- 1.18. [Нэхэмжлэхийг хэдэн хүн рүү илгээж болох вэ?](#)
- 1.19. [Нэхэмжлэх илгээхэд гүйлгээний лимит байгаа юү?](#)
- 1.20. [Энэ аппликэйшныг ашиглахад дата хэр их унадаг вэ?](#)
- 1.21. [“Байршил ойрхон” цэсийг хэрхэн үр дүнтэй ашиглах вэ?](#)
- 1.22. [Social Pay-н төлбөр шилжүүлэх сувгуудын мэдээллийн боломж, хязгаарлалтууд нь юу вэ?](#)

ХОЁР. SOCIALPAY_хэрэглээтэй холбоотой

- 2.1. [Интернэт банк, смарт банкны нэвтрэх нэр ялгаатай бол алинаар нь нэвтрэх вэ?](#)
- 2.2. [Утасны дугаар, дансны дугаар зэрэг мэдээллээ яаж өөрчлөлт вэ?](#)
- 2.3. [Нөгөө хүнийхээ дансны дугаарыг мэдэж байвал мөнгө шилжүүлж болох үү?](#)
- 2.4. [Утасны дугаар, имэйл хаягаар мөнгө шилжүүлэхэд тухайн хүнийхээ мэдээллийг хадгалсан байх шаардлагатай юү?](#)
- 2.5. [Олон данстай хүн рүү мөнгө шилжүүлбэл аль данс рүү нь орох вэ?](#)
- 2.6. [SocialPay-ээр шилжиж ирсэн мөнгийг салбар дээр очиж бэлнээр авч болох үү?](#)
- 2.7. [Дугаараа сольж өөр дугаар баривал над рүү шилжүүлсэн мөнгө өөр хүнд очих үү?](#)
- 2.8. [Буруу утасны дугаар рүү мөнгө илгээвэл яах вэ?](#)
- 2.9. [Сошиал дансны үлдэгдлээ яаж шалгах вэ?](#)
- 2.10. [Ижилхэн нэртэй өөр хүн рүү мөнгө шилжүүлбэл яах вэ?](#)
- 2.11. [Гадаадын дугаар рүү гүйлгээ хийж болох үү?](#)
- 2.12. [4 оронтой кодоо мартвал яах вэ?](#)
- 2.13. [Сошиал дансандаа мөнгөгүй бол яаж орлого хийх вэ?](#)
- 2.14. [Дансны хуулга, сүүлд хийгдсэн гүйлгээний мэдээллээ яаж харах вэ?](#)
- 2.15. [Аппликейшндаа утасны дугаараа холбочихоод байхад гүйлгээ хийх гэхээр найзуудын маань жагсаалт гарч ирэхгүй хоосон байгаад байх юм?](#)
- 2.16. [Аюулгүй байдал муу юм биш үү? Миний утсыг өөр хүн аваад гүйлгээ хийвэл яанаа?](#)
- 2.17. [Утсаа алдсан тохиолдолд, миний дансыг гадны этгээд ашиглах боломжтой юү?](#)
- 2.18. [Миний утасны дугаар, имэйл хаяг гэх зэрэг мэдээллийг гуравдагч этгээд өөрийн дансандаа холбох боломжтой юү?](#)
- 2.19. [Мөнгө илгээгдэхгүй алдаа заавал яах вэ?](#)
- 2.20. [Сошиал Пэй бүтээгдэхүүнийг суулгах явцад алдаа гарвал яах вэ?](#)
- 2.21. [Байршил ойрхон” цэст ойрхон байгаа хэрэглэгч нар харагдахгүй бол яах вэ?](#)

НЭГ. SOCIALPAY_ерөнхий ойлголттой холбоотой

1.1 Social Pay гэж юу вэ?

- Утасны дугаар, имэйл хаяг болон twitter, facebook ашиглан бусад руу мөнгө шилжүүлэх, бусдаас мөнгө нэхэмжлэх боломжтой, санхүүгийн харилцааг хамгийн хялбараар шийдэх цоо шинэ үйлчилгээ.

1.2 Үйлчилгээний боломжууд

- Мөнгө илгээх
 - Утасны дугаар, и-мэйл хаяг болон Twitter, Facebook сүлжээ ашиглан мөнгө шилжүүлэх;
 - Мөн өөрт ойрхон байгаа хүмүүс рүүгээ GPS байршил ашиглан мөнгө илгээх;
- Мөнгө нэхэмжлэх
 - Бусдаас мөнгө авах, төлбөр хуваалцах хүсэлтээ олон хүн рүү зэрэг нэхэмжлэх;
- Чатлах
 - Хувийн чат үүсгэж харилцах;
- Онлайнаар бүртгүүлэх
 - Голомт банкны харилцагч болохын тулд заавал банкны салбар орох шаардлагагүй, онлайнаар бүртгүүлэх боломжтой;

1.3 Үйлчилгээний нөхцөл

- Үнэгүй. Ямар ч шимтгэл хураамж байхгүй.

1.4 Аппликейшн хэрхэн татаж авах вэ?

- App Store /Play Store → Search хэсэгт → SocialPay гэж бичиж хайх → Get, Install /Free, Install товч дарж татаж авах

1.5 Аппликейшн татаж авахад төлбөртэй юу?

- Үнэгүй

1.6 Аппликейшн татаж авахад ашигладаг нууц үгээ мартсан бол яах вэ?

- iOS → <https://appleid.apple.com/> линкээр орж, Forgot Apple ID or password дээр дараад мартсан нууц үгээ сэргээх

1.7 Хэрхэн бүртгүүлэх вэ?

- SocialPay аппликейшнийг гар утсан дээрээр татаж авна.
- Бүртгүүлэх сонголтыг хийж зааврыг дагана.*
 - Голомт банкны харилцагч бол интернэт банк үйлчилгээний эрхээ ашиглан нэвтрэх;
 - Хэрэв Голомт банкны харилцагч болж амжаагүй, эсвэл Голомт банкны интернэт банк үйлчилгээг хараахан аваагүй байгаа бол Бусад хэрэглэгч сонголтыг хийж, өөрийн дэлгэрэнгүй мэдээллийг оруулан баталгаажуулах**

*Хэрэв танд бусдаас ирсэн мөнгө, нэхэмжлэх хүлээгдэж байгаа бол бүртгэлээ хийхэд автоматаар танд ирэх болно.

**Цоо шинэ харилцагчийн хувьд харилцах данс нээгдэж, Интернэт банк болон SocialPay үйлчилгээний эрх олгогдоно. Голомт банкны харилцагч бол интернэт банк үйлчилгээг зайнаас олгоно.

1.8 Утсанд тавигдах шаардлага

- iOS 9.0-ээс дээш, Android 4.0-ээс дээш үйлдлийн системтэй байх.

1.9 Утасныхаа version-г хэдээс дээш байгааг нь яаж мэдэх вэ?

- iOS → Settings → General → Software update → iOS текстийн ард байгаа тоог харах
- Android → Settings → About device → Android version хэсэгт байгаа тоог харах

1.10 Ухаалаг утасгүй бол яах вэ?

- Тун удахгүй www.egolomt.mn вэб хуудсаар дамжуулан “SocialPay” үйлчилгээнд бүртгүүлэх, гүйлгээ хийх боломж нээгдэнэ. Системийн хөгжүүлэлт хараахан дуусаагүй байгаа тул та бүхэнд эргэн мэдэгдэх болно.
- Хэрэв танд интернэт сүлжээнд холбогдох боломж байхгүй бол манай банкны Мобайл банк 2.0 үйлчилгээг ашиглан төлбөр тооцоогоо гүйцэтгэх боломжтой.

1.11 Хэрхэн аппликэйшндээ нэвтрэх вэ?

- Интернэт банкны нэвтрэх нэр, нууц үгээрээ нэвтрэнэ. Хэрэв онлайнаар бүртгүүлсэн бол банкнаас гар утасны дугаараар ирүүлсэн нэвтрэх нэр, имэйлээр ирүүлсэн нэвтрэх нууц үгээр тус тус нэвтрэнэ.

1.12 Сошиал данс гэж юу вэ?

- Сошиал сувгуудаар дамжуулан мөнгө хүлээн авах болон шилжүүлэх дансыг хэлнэ.

1.13 Ямар данс холбож болох вэ?

- Харилцах эсвэл хугацаагүй хадгаламжийн төгрөгийн данс.

1.14 Шилжүүлсэн мөнгө хэзээ нөгөө дансандаа орох вэ?

- Гүйлгээ автоматаар хийгдэх бөгөөд 10 секундын дотор хүлээн авагчдаа очно. Хэрвээ хүлээн авагч нь хараахан үйлчилгээнд бүртгүүлж амжаагүй байгаа бол бүртгүүлсэн даруй хүлээн авагчийн дансанд орно.

1.15 Сошиал пин гэж юу вэ?

- Гүйлгээ хийх үед ашиглагдах 4 оронтой тоо. Уг кодыг харилцагч өөрөө үүсгэнэ.
- Та гүйлгээг хурууны хээгээр баталгаажуулахаар сонгосон ч, данс/утасны дугаар гэх мэт мэдээллээ шинэчлэхэд сошиал пин ашиглагдах тул та марталгүй санаж байх хэрэгтэй.
- Таны мэдээлэл, гүйлгээний нууцлалыг хангах хэрэгсэл тул бусдад задалж болохгүй. Мөн утсан дээрээ өөрөөсөө бусад хүний хурууны хээг бүртгүүлэхгүй байхад анхаарна уу.

1.16 Хэрхэн аппликэйшнаасаа гарах вэ?

- Нэвтрэх үйлдэл нь ганцхан удаа хийгдэх ба та аппликейшн руугаа орох болгондоо уг үйлдлийг ахин дахин хийх шаардлагагүй.
- Хэрэв “Тохиргоо” цэснээс гарах сонголтыг хийж апп-аасаа гарсан бол дахин үйлчилгээнд нэвтрэхэд дахин сошиал пин тохируулах шаардлагатай.
- Мөн та утсаа сольж, өөр утаснаас нэвтрэвэл мөн адил сошиал пин-гээ дахин тохируулна.

1.17 SocialPay-ээр шилжүүлсэн мөнгө болон нэхэмжлэхийн талаар нөгөө хүн маань яаж мэдэх вэ?

- Бүх төрлийн гүйлгээнд шилжүүлэгч болон хүлээн авагчид push notification, имэйл гэсэн 2 сувгаар мэдээлэл очно.
- Мөн нэмэлтээр шилжүүлэгч ямар суваг ашиглан гүйлгээ хийснээс хамааруулан тэр сувгаар нь хүлээн авагчид давхар мэдээлэл очно.
- Утасны дугаараар хийвэл мессэж, Имэйлээр бол имэйл, facebook-ээр бол messenger message, twitter-ээр бол private message.
- Утасны дугаараар илгээх мессэж мэдээлэл нь зөвхөн төлбөр хүлээн авагч талд очно. Төлбөр шилжүүлэгч талд мессэжээр мэдээлэл ирэхгүй.

1.18 Нэхэмжлэхийг хэдэн хүн рүү илгээж болох вэ?

- Хамгийн ихдээ 9 хүн рүү зэрэг нэхэмжлэх илгээх боломжтой. Бүх хүнээс ижил дүнгээр буюу тогтмол дүнгээр нэхэмжлэх боломжтой бөгөөд хүн тус бүрт ялгаатай дүн оруулж болохгүй.

1.19 Нэхэмжлэх илгээхэд гүйлгээний лимит байгаа юу?

- Гүйлгээний лимит байхгүй. Харин та 1 удаадаа хамгийн багадаа 100₮, хамгийн ихдээ 1 сая ₮-ийг үйлдлээр нэхэмжлэх боломжтой.
- Өөрөөр хэлбэл, 1 өдөрт 1 сая ₮-өөр хэдэн ч удаа нэхэмжлэх илгээх боломжтой гэсэн үг юм.

1.20 Энэ аппликэйшнийг ашиглахад дата хэр их унадаг вэ?

- 5 мин ашиглахад ойролцоогоор 6 kb зарцуулдаг бөгөөд Мобикомын задгай тарифаар (1kb=0.09₮) тооцвол ойролцоогоор 50 мөнгө зарцуулна.
- Аппликейшн татахад ойролцоогоор iOS бол 35mb, Android бол 20mb унаж байгаа.

1.21 “Байршил ойрхон” цэсийг хэрхэн үр дүнтэй ашиглах вэ?

- Энэхүү цэсийг ашиглан та огт танихгүй хүн рүүгээ ч шилжүүлэг хийх, чатлах, нэхэмжлэх илгээх боломжтой. Аппликэйшн тань нээлттэй үед 100м орчимд байгаа аппликэйшн татсан хүмүүс танд харагдах болно. Хэрэв та худалдаа, үйлчилгээний бизнес эрхэлдэг бол энэ боломж танд хамгийн хэрэгтэй цэс юм.
- Хэрэв та Iphone утастай бол “байршил ойрхон” цэсийг “widget”-тээ оруулснаар апп-руу нэвтрэхгүйгээр, дэлгэцээ баруун тийш чирэх төдийд ойр орчимд байгаа хүмүүстээ харагдах боломжтой. “Widget” цэсээ “edit” хийснээр та ганцхан үйлдлээр маш хурдан хугацаанд ойр орчмынхоо хүмүүст харагдан төлбөр хүлээн авах боломжтой.

1.22 Social Pay-н төлбөр шилжүүлэх сувгуудын мэдээллийн боломж, хязгаарлалтууд нь юу вэ?

- Утасны дугаар: Үйлчилгээнд бүртгэлтэй бүртгэлгүй, утасны contact list-д хадгалсан, хадгалаагүй бүх төрлийн дугаар луу шилжүүлж болно. (Зөвхөн МУ-д бүртгэлтэй дугаар, гадаад дугаар болохгүй)
- Имэйл хаяг: Үйлчилгээнд бүртгэлтэй бүртгэлгүй, утсандаа хадгалсан, хадгалаагүй бүх төрлийн имэйл хаягаар мөнгө шилжүүлж болно.
- Твиттер хаяг: Үйлчилгээнд бүртгэлтэй бүртгэлгүй, утсандаа хадгалсан, хадгалаагүй бүх төрлийн имэйл хаягаар мөнгө шилжүүлж болно.
- Фэйсбүүк хаяг: Зөвхөн Social Pay апп татсан, фэйсбүүк найзууд нь харагдна.
- Байршил ойрхон: Зөвхөн Social Pay апп татсан, 100м радиустай тойрог дотор байгаа, апп нээсэн эсвэл widget-ээ нээсэн хүмүүс харагдна.

ХОЁР. SOCIAL PAY_хэрэглээтэй холбоотой

- 2.1. **Интернэт банк, смарт банкны нэвтрэх нэр ялгаатай бол алинаар нь Сошиал Пэй руу нэвтрэх вэ?**
 - Интернэт банкны нэвтрэх нэр нууц үгээр Сошиал Пэй руу нэвтрэнэ.
- 2.2. **Утасны дугаар, дансны дугаар зэрэг мэдээллээ яаж өөрчлөлт вэ?**
 - SocialPay аппликейшн руугаа нэвтрэн орж “Холболт” хэсгээс сонгон оруулсан мэдээллээ шинэчлэх боломжтой.
- 2.3. **Нөгөө хүнийхээ дансны дугаарыг мэдэж байвал мөнгө шилжүүлж болох уу.**
 - SocialPay үйлчилгээ нь зөвхөн сошиал сувгуудаар дамжуулан гүйлгээ хийдэг ба дансны дугаараар дамжуулан мөнгө шилжүүлэх боломжгүй. Танд интернэт банк болон Смарт банк үйлчилгээг санал болгож байна.
- 2.4. **Утасны дугаар, имэйл хаягаар мөнгө шилжүүлэхэд тухайн хүнийхээ мэдээллийг хадгалсан байх шаардлагатай юу?**
 - Шаардлагагүй. Утасны дугаар, имэйл хаяг сонгох хэсэгт шууд гараас тухайн дугаар, хаягийг бичиж оруулах боломжтой.
- 2.5. **Олон данстай хүн рүү мөнгө шилжүүлбэл аль данс руу нь орох вэ?**
 - Хүлээн авагч SocialPay үйлчилгээндээ аль дансаа холбож тохируулсанаас хамааран, тухайн данс руу нь таны шилжүүлсэн мөнгө орно.
 - Хүлээн авагч “Хэрхэн бүртгүүлэх вэ?” зааврын дагуу үйлчилгээнд бүртгүүлсэнээр мөнгө нь автоматаар орно.
 - Хэрэв үйлчилгээнд бүртгүүлээгүй 14 хоног болсон тохиолдолд илгээсэн гүйлгээ цуцлагдаж, таны сошиал данс руу эргэн орох болно.
- 2.6. **SocialPay-ээр шилжиж ирсэн мөнгийг салбар дээр очиж бэлнээр авч болох уу?**
 - Хэрэв та онлайнгаар харилцагчаар бүртгүүлсэн бол болохгүй. Уг төрлийн харилцагч нь “Хязгаарлагдмал” буюу бэлэн зарлагын гүйлгээ хийх эрхгүй байдаг тул SocialPay үйлчилгээгээр шилжиж ирсэн мөнгийг зөвхөн аппликейшнаар дамжуулан хүлээн авах боломжтой.
 - Харин өмнө нь Голомт банкны харилцагч байсан бол үйлчилгээнд тохируулсан сошиал данснаасаа зарлагын гүйлгээ хийлгэх боломжтой.
- 2.7. **Дугаараа сольж өөр дугаар баривал над руу шилжүүлсэн мөнгө өөр хүнд очих уу?**
 - Үгүй, таны данс руу орно, таны данстай холбогдсон.
 - Хэрэв та аппликейшнд бүртгүүлсэн дугаараа ашиглахаа больсон бол тань руу илгээсэн гүйлгээ “хүлээгдэж буй” төлөвт байж байгаад 14 хоногийн дараа цуцлагдана.
 - Харин таны хуучин дугаарыг өөр хүн аппликейшнд бүртгүүлбэл таны данснаас холболт шууд сална. Иймээс утасны дугаараа сольсон тухай бүртээ аппликейшн руугаа орж дугаараа шинэчилж байна уу.
- 2.8. **Буруу утасны дугаар руу мөнгө илгээвэл яах вэ?**
 - Хэрэв хүлээн авагч нь Social Pay үйлчилгээнд бүртгэлгүй бол таны гүйлгээ “хүлээгдэх” төлөвт шилжих бөгөөд та гүйлгээгээг цуцлах бүрэн боломжтой.
 - Та мөнгөө илгээхийн өмнө хүлээн авагч нь хэвээр байгаа эсэх, чатлах гэх мэт урьдчилан магадлах, шалгах арга хэмжээ авч болно.
 - Утсан дээр бүртгэлтэй дугаарын жагсаалтнаасаа хүлээн авагчийг сонгох нь буруу дугаарт илгээх эрсдэлийг бууруулна.
 - Гараар бичиж оруулах тохиолдолд утасны дугаарыг зөв бичсэн эсэхийг сайтар нягтлан шалгахыг зөвлөө.
- 2.9. **Сошиал дансны үлдэгдлээ яаж шалгах вэ?**
 - Аппликейшний хувийн мэдээллээ өөрчлөх хэсэгт нэвтрэн дансны үлдэгдлээ харж болно.
- 2.10. **Ижилхэн нэртэй өөр хүн рүү мөнгө шилжүүлбэл яах вэ?**
 - Мөнгө хүлээн авах хүний овог нэрийг бүтнээр нь харуулдаг тул овогийг нь сайтар шалгана уу.
 - Тухайн хүнээсээ мөнгөө нэхэмжилж буцаан авна.
 - Хэрэв хүлээн авагч нь Social Pay үйлчилгээнд бүртгэлгүй бол таны гүйлгээ “хүлээгдэх” төлөвт шилжих бөгөөд та гүйлгээгээг цуцлах бүрэн боломжтой.
 - Та мөнгөө илгээхийн өмнө хүлээн авагч нь хэвээр байгаа эсэх, чатлах гэх мэт урьдчилан магадлах, шалгах арга хэмжээ авч болно.
- 2.11. **Гадаадын дугаар руу гүйлгээ хийж болох уу?**
 - Болохгүй. Зөвхөн 8 оронтой буюу Монгол улсын оператор байгууллагуудын утасны дугаарууд руу гүйлгээ хийх боломжтой.
- 2.12. **Сошиал дансандаа мөнгөгүй бол яаж орлого хийх вэ?**
 - Та интернэт банк, смарт банк үйлчилгээнд нэвтрэн өөрийн данс хооронд гүйлгээ хийх замаар сошиал дансандаа орлого нэмж болно. Social Pay-д нэвтрэхдээ ашигладаг нэвтрэх нэр, нууц үгийг ашиглана.
 - Та аль ч банкны данснаас бэлнээр болон бэлэн бусаар Сошиал дансандаа орлого хүлээн авах боломжтой.
 - Social Pay үйлчилгээний хувийн мэдээллээ өөрчлөх хэсэгт нэвтрэн, Сошиал дансаар сонгож холбосон дансаа сольж, оронд нь зарлагын гүйлгээ хийгдэх боломжтой бусад данснуудаасаа сонгож болно.
- 2.13. **4 оронтой кодоо мартвал яах вэ?**
 - Аппликейшнаасаа “Гарах /Холболт” салгах товч даран гараад эргэн интернэт банкны эрхээрээ нэвтрэн орох үйлдэл хийх. Ахин нэвтрэн ороход шинээр пин код тохируулах боломжтой.

2.14. Дансны хуулга, сүүлд хийгдсэн гүйлгээний мэдээллээ яаж харах вэ?

- Та интернэт банк, смарт банк үйлчилгээнд нэвтрэн сошиал дансныхаа орлого зарлагын мэдээллийг дэлгэрэнгүйгээр харж болно.
- Social Pay үйлчилгээний “Нийт” цэсээр таны нийт харьцсан хүмүүсийн жагсаалт харагдах бөгөөд та хүн тус бүрийг сонгож, тухайн хүнтэй үүсгэсэн төлбөр тооцооны харилцаагаа дэлгэрэнгүй харах боломжтой.

2.15. Аппликейшндаа утасны дугаараа холбочихоод байхад гүйлгээ хийх гэхээр найзуудын маань жагсаалт гарч ирэхгүй хоосон байгаад байх юм?

- Та эхлээд SocialPay аппликейшнаасаа контакт руугаа хандах эрхээ нээсэн эсэхээ шалгаж үзнэ үү.
- iOS тохиргоо: Аппликейшний зүүн дээд буланд байрлах icon дээр дарж “Тохиргоо” хэсэгт дарах → Contacts тохиргоог On болгох. Эсвэл гар утасныхаа Settings цэс рүү нэвтрэн орж доош нь гүйлгэн SocialPay апп-ыг сонож мөн адил үйлдэл хийх.
- Android тохиргоо: Гар утасныхаа Settings цэс рүү орох → Applications/Application manager → Permissions → Contacts тохиргоог On болгох.

2.16. Аюулгүй байдал муу юм биш үү? Миний утсыг өөр хүн аваад гүйлгээ хийвэл яанаа?

- Гүйлгээ хийхийн тулд зөвхөн таны мэдэх 4 оронтой пин кодыг оруулах эсвэл хурууны хээгээр тухайн гүйлгээг баталгаажуулах шаардлагатай байдаг.
- Иймээс гар утсан дээрээ бусдын хурууны хээг таниулах, сошиал кодоо бусдад дамжуулахгүй байх, бусдын олж мэдэхээргүй тоон утгуудаар кодоо үүсгэж, кодоо нууцлахыг зөвлөө.
- Таны данснаас гүйлгээ хийгдсэн талаарх мэдээллийг таны имэйл хаягаар илгээдэг. Мөн та сошиал данс болгон холбосон дансаа “Изи инфо” үйлчилгээнд бүртгүүлэн орлого зарлагын мэдээллээ гар утсандаа мессэж хэлбэрээр авч болно. Изи инфо үйлчилгээг салбарт хандан, эсвэл интернэт банк үйлчилгээндээ (www.egolomt.mn) нэвтрэн авч болно.

2.17. Утсаа алдсан тохиолдолд, миний дансыг гадны этгээд ашиглах боломжтой юу?

- Боломжгүй, гадны этгээд таны утас руу нэвтэрсэн байлаа ч, гүйлгээ хийхийн тулд зөвхөн таны мэдэх 4 оронтой пин кодыг оруулах эсвэл хурууны хээгээр тухайн гүйлгээг баталгаажуулах шаардлагатай болно.
- Та утсаа алдсан бол, өөр утаснаас үйлчилгээндээ дахин нэвтрэн, сошиал пин кодоо дахин шинэчлэх арга хэмжээ авснаар гадны этгээд таны данснаас гүйлгээ хийх боломжийг бүрэн, баталгаажуулж болно.
- Та дугаараа яаралтай сэргээж, өөр дээрээ авснаар өөрт тань ирсэн гүйлгээний мэдээллийг цаг алдалгүй авах боломжтой.

2.18. Миний утасны дугаар, имэйл хаяг гэх зэрэг мэдээллийг гуравдагч этгээд өөрийн дансандаа холбох боломжтой юу?

- Таны Сошиал Пэй үйлчилгээнд холбохоор бүртгүүлсэн утасны дугаар, имэйл хаяг руу бид шалгах дугаар илгээх бөгөөд зөвхөн таны дугаарыг эзэмшиж, ашиглаж буй хүн л банкнаас ирүүлсэн нууц дугаарыг мэдэж, утасны дугаараа баталгаажуулах боломжтой тул гуравдагч этгээд таны мэдээллийг ашиглах боломжгүй юм.

2.19. Мөнгө илгээгдэхгүй алдаа заавал яах вэ?

- Дансны үлдэгдэл хүрэлцэхгүй байх магадлалтай тул Хэрэглэгчийн мэдээлэл хэсэгт байрлах “Дансны үлдэгдэл харах” товч дээр дарж үлдэгдэлээ шалгах;
- Үлдэгдэл хүрч байхад гүйлгээ хийгдэхгүй байвал 1800-1646 лавлах утас руу хандана уу;

2.20. Сошиал Пэй бүтээгдэхүүнийг суулгах явцад алдаа гарвал яах вэ?

- Интернэт банкны харах эрхтэй харилцагч нар нь Сошиал Пэй үйлчилгээг авах боломжгүй. Учир нь ийм эрхтэй харилцагч нар нь гүйлгээ хийх эрхгүй учир гүйлгээний апп суулгах боломжгүй. Энэ тохиолдолд харилцагч өөрийн биеэр салбарт хандаж, интернэт банкны эрхийн түвшнөө өөрчлүүлэх ёстой.
- Хэрэв та Голомт банкинд зөвхөн хугацаатай хадгаламжийн данстай бол Сошиал Пэй үйлчилгээнд бүртгүүлэх боломжгүй. Хугацаатай хадгаламжийн данс нь зарлага хийх боломжгүй бөгөөд Сошиал Пэй үйлчилгээнд ганцхан зарлагын гүйлгээ хийгддэг данс холбогдох боломжтой. Гэхдээ банкнаас олгосон интернэт банк эрхээрээ www.egolomt.mn вэбсайт руу нэвтрэн харилцах данс, хугацаагүй хадгаламжийн дансуудыг өөртөө шинээр нээж болно. Үүний дараа таны шинээр нээсэн дансууд Сошиал Пэй үйлчилгээнд холбогдох бүрэн боломжтой.

2.21. “Байршил ойрхон” цэст ойрхон байгаа хэрэглэгч нар харагдахгүй бол яах вэ?

- Утасныхаа “Location” боломжийг асаасан эсэхээ шалгана уу.